ДОРНОД АЙМАГ
БАЯНТҮМЭН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 27 өдөр Дугаар 12/02 Цагаан дэрс

Байгалийн нөөцийн хамтын менежментийн
нөхөрлөл байгуулахыг дэмжих тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалт, 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Өлзийт багийн иргэдийн Нийтийн Хурлын 2026 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Баянтүмэн сумын Өлзийт багийн нутаг дэвсгэрт байгалийн нөөцийн хамтын менежментийн “Бумбан” нөхөрлөлийг үүсгэн байгуулахыг дэмжсүгэй.

2.Буман нөхөрлөлийн хариуцан хамгаалах газар нутгийн хэмжээ, нэршлийг хавсралтаар баталсугай.

3.Холбогдох хуулийн дагуу үйл ажиллагаа явуулж үр дүнг тайлагнахыг нөхөрлөлийн ахлагчид үүрэг болгосугай.

4.Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлтэй гэрээ байгуулж, менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж үр дүнг тайлагнахыг сумын Засаг дарга (П.Гунгаацэрэн)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА Ж.БАТЧУЛУУН

2105001025